

2022-2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАЙГУУЛСАН ХАМТЫН ГЭРЭЭ

ГЭРЭЭНИЙ ТАЛУУД

Ажил олгогчийн төлөөлөгч: "РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ" УЛСЫН
ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР
Ажилтны төлөөлөгч: "РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ" УЛСЫН
ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН АЖИЛТНЫ
ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРОО

2022 оны 05-р сарын 23-ны өдөр

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү гэрээг Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ конвенц, Хөдөлмөрийн тухай хууль, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиудыг үндэслэн нэг талаас "Радио Телевизийн Үндэсний Сүлжээ" УТҮГ-ын захиргаа /цаашид ажил олгогч гэх/ нөгөө талаас ажилчдыг төлөөлж "Радио Телевизийн Үндэсний Сүлжээ" УТҮГ-ын Ажилтны үйлдвэрчний эвлэлийн хороо /цаашид ажилтны төлөөлөгч/ хамтад нь талууд гэх/ харилцан тохиролцож байгуулав.
- 1.2 Тус гэрээгээр ажилтны хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах буюу хуулиар тогтоосон баталгаанаас илүү нөхцөлөөр хангах, хуулиар шууд зохицуулаагүй бусад нийгэм болон эдийн засгийн харилцааг зохицуулна.
- 1.3 Хамтын гэрээ нь хоёр жилийн хугацаанд үйлчилнэ.
- 1.4 Гэрээний хугацаа дуусахад шинээр гэрээ байгуулаагүй, нэмэлт өөрчлөлт оруулаагүй бол талууд харилцан тохиролцож, анх байгуулсан хугацаанаас илүүгүй хугацаагаар сунгаж болно.
- 1.5 Хамтын гэрээнд талуудын төлөөлөгчид гарын үсэг зурсан өдрөөс хойш 10 хоногт багтаан харьяа нутаг дэвсгэрийн хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн байгууллагад бүртгүүлэх үүргийг ажил олгогч хариуцна.
- 1.6 Хамтын гэрээ нь талууд гарын үсэг зурж, харьяа нутаг дэвсгэрийн хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн байгууллагад бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.
- 1.7 Байгууллагын харьяалал, удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөн нөхцөлд хамтын гэрээ мөн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 1.8 Талууд хамтын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналаа нөгөө талд бичгээр гаргаж, тухайн үед хэлэлцэн нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 1.9 Өөрчлөлт хийсэн тухай бүр хэлэлцэж нэмэлтээр хавсаргаж хүчин төгөлдөр мөрдөж ажиллана. Гэрээний заалт өөрчлөгдөөгүй тохиолдолд дараагийн гэрээ байгуулах хугацаа хүртэл энэхүү гэрээ нь хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 1.10 Талууд гэрээнд заасан аливаа асуудалд тэгш эрхтэй оролцоно.
- 1.11 Талууд хамтын гэрээг байгуулах, нэмэлт өөрчлөлт оруулахдаа цаашид сайжруулан боловсронгуй болгох зарчмыг баримтална.
- 1.12 Энэхүү хамтын гэрээнд байгууллагын нийт ажилтан хамрагдана. Үйлдвэрчний гишүүний татвар төлдөггүй ажилтан нь АҮЭХорооноос олгох хөнгөлөлтөд хамаарахгүй.

Handwritten signature

1.13 ЛАМТЫН ГЭРЭЭГ 5 хувь үйлдэл, ламтын гэрээнд өрсөлдөгчид үйлдэл...

Хоёр. Ажил эрхлэлт, ажлын байрны талаар Захиргааны хүлээх үүрэг

2.1 Ажил олгогч нь үйлдвэрлэл үйлчилгээг тасралтгүй хэвийн явуулах нөхцөл боломжийг бүрдүүлж ажилтнуудыг тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, ажлын таатай нөхцөлөөр бүрэн хангана.

2.2 Аж ахуй нэгж байгууллага болон түүний салбар нэгж татан буугдсан, ажлын байр хасагдсан, орон тоо цөөрсөн, ажилтны тоог цөөрүүлсэн, ажилтан мэргэжил, мэргэшлийн түвшин, ур чадвар, ажлын гүйцэтгэлийн болон эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж байгаа ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон, ар гэрийн гачигдлаар хөдөлмөр эрхлэлтийн харилцаа цуцлагдсан ажилтанд нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй эсэхээс үл хамааран харилцаа холбооны салбарт ажилласан жилээр тооцон олгоно. Мөн ажилтныг бөөнөөр халах үед дор дурдсан тэтгэмжийг ажилтанд олгоно. Үүнд:

- 2.2.1 6 сараас 2 жил хүртэл ажилласан бол 2 сарын
- 2.2.2 2 жилээс 5 жил хүртэл ажилласан бол 3 сарын
- 2.2.3 5 жилээс 10 жил хүртэл ажилласан бол 4 сарын
- 2.2.4 10 жилээс 15 жил хүртэл ажилласан бол 6 сарын
- 2.2.5 16 жилээс 20 жил хүртэл ажилласан бол 8 сарын
- 2.2.6 21-ээс дээш жил ажилласан бол 10 сарын дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмж олгоно.

2.3 Ажилтныг ажлаас халах, сахилгын шийтгэл оногдуулахдаа Хөдөлмөрийн тухай хууль, "Радио Телевизийн Үндэсний Сүлжээ" УТҮГ-ын хөдөлмөрийн дотоод журмыг баримтална.

2.3.1 Сахилгын шийтгэлээр халагдсан эсхүл өөрийн санаачлагаар ажлаас чөлөөлөгдсөн бол тэтгэмж олгохгүй.

Гурав. Цалин хөлс, нэмэгдэл хөлс, шагнал, тэтгэмж

3.1 "Радио Телевизийн Үндэсний Сүлжээ" УТҮГ-ын нийт ажилтны цалин, нэмэгдэл урамшууллыг Монгол Улсын Засгийн газраас тогтоосон төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн жишгийн дагуу үндсэн цалинг тогтоож олгох бөгөөд сар бүр үндсэн цалингаас үр дүн, мэргэшлийн зэрэг, ажилласан жилийн нэмэгдэл, ур чадварын нэмэгдлийг тус тус олгоно. Цалинг сар бүрийн 15, 28-ны өдрүүдэд олгоно. Үүнд:

- 3.1.1 Үр дүн урамшууллыг 25%
- 3.1.2 Мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдлийг 5-15%
- 3.1.3 Ур чадварын нэмэгдлийг 10-20%
- 3.1.4 Ажилласан жилийн нэмэгдлийг харилцаа холбооны салбарт болон тус байгууллагад ажилласан жилийг харгалзан дараах байдлаар олгоно. Үүнд:
 - А. 2-4 жил хүртэл ажилласан бол үндсэн цалингийн 2 /хоёр/ хувь
 - Б. 5-7 жил хүртэл ажилласан бол үндсэн цалингийн 4 /дөрөв/ хувь
 - В. 8-10 жил хүртэл ажилласан бол үндсэн цалингийн 6 /зургаа/ хувь
 - Г. 11-15 жил хүртэл ажилласан бол үндсэн цалингийн 8 /найм/ хувь

Минист

Д.10 0а түүнээс дээш жил ажилласан бол үндэс
хувь

3.2 Илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг 2 дахин нэмэгдүүлж олгоно. Ээлжийн инженер техникийн ажилтан нарыг илүү цагаар ажиллуулахгүй зарчмыг баримтлах, зайлшгүй илүү цагаар ажилласан бол илүү цагийн мөнгийг сард нь тооцож олгоно.

3.3 Нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол өдөр, шөнийн ээлж ялгаварлахгүйгээр түүний дундаж цалин хөлсийг 2 дахин нэмэгдүүлж олгоно. "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн 109.9 дүгээр заалтыг үндэслэн ээлжийн болон графикаар ажилладаг ажилтанд энэхүү заалт мөн адил хамаарна.

3.4 Шөнийн цагаар /22.00-06.00/ ажилласан ээлжийн ажилтны 1 цагийн цалин хөлсийг хөдөлмөрийн хөлсний 1 цагийн 1000 төгрөгөөр тооцон бодож олгоно.

3.5 Ажилтныг илүү цагаар, долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр шөнийн цагт ажиллуулсан бол хамтын гэрээнд заасан илүү цаг, долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдрийн нэмэгдэл хөлс дээр нэмээд шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг ажилтны цалин хөлсийг 1 цагийн 1000 төгрөгөөр тооцон бодож олгоно. /Ээлжийн ажилтанд хамаарахгүй/

3.6 Тус газрын жилийн эцсийн үр дүнг тооцож жилийн ажлын үр дүнг харгалзан урамшуулал олгоно. Жилийн эцсийн үр дүнгийн урамшуулал олгох тохиолдолд дараах ажилчдыг хамааруулахгүй болно. Үүнд:

3.6.1 Сахилгын шийтгэл хүлээсэн

3.6.2 Нийт ажлын цаг ашиглалт 90%-д хүрээгүй

3.7 Ажил олгогч нь ажилтантай тохиролцож ажил хослон гүйцэтгүүлсэн, эзгүй байгаа ажилтны ажил үүргийг түр орлон гүйцэтгүүлсэн, ажилтны ажлын цагт багтаан ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй нэмэлт ажил үүрэг гүйцэтгүүлсэн тохиолдолд үндсэн цалингийн 20-40 хувиар тооцож нэмэгдэл олгоно.

3.8 Харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбарын ажилтнуудын албан тушаалын болон тарифт цалингийн доод жишиг Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1.2 дахин нэмэгдүүлснээс багагүй /504.000 мянган төгрөг/ байх бөгөөд, хөдөлмөрийн хөлсний цагийн үнэлгээ нь 3000 төгрөг байна. Хэрэв улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ шинэчлэн өөрчлөгдөхөд түүнийг дагаж 1.2 дахин нэмэгдүүлж тооцно.

3.9 Ажил олгогч нь ажилтнуудын цалин хөлсийг хүн амын амьжиргааны өртгийн өөрчлөлт, бодит инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх, ижил үнэлэмжтэй ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажилтны цалин хөлсний хэмжээ адил байх зарчмыг тус тус баримтална. Гэрээний хугацаанд инфляцын түвшинтэй уялдуулж 20 – иос доошгүй хувиар нэмэгдүүлнэ.

Тэтгэмж

3.10 Ажилтан өндөр настны тэтгэвэрт гарсан бол харилцаа холбооны салбарт ажилласан жилийг харгалзан 1-10 сарын тэтгэмжийг дараах байдлаар олгоно. Үүнд:

3.10.1 6 сараас 5 жил хүртэл ажилласан бол дундаж цалин хөлстэй тэнцэх 1 сарын тэтгэмж

3.10.2 6-11 жил хүртэл ажилласан бол дундаж цалин хөлстэй тэнцэх 3 сарын тэтгэмж

- 3.10.3 12-17 жил хүртэл ажилласан бол дундаж цалин хөлстэй тэнцэх 8 сарын тэтгэмж
- 3.10.4 18-23 жил хүртэл ажилласан бол дундаж цалин хөлстэй тэнцэх 8 сарын тэтгэмж
- 3.10.5 24-өөс дээш жил ажилласан бол дундаж цалин хөлстэй тэнцэх 10 сарын тэтгэмжийг тус тус олгоно.

Шагнал

- 3.11 Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 27.6, 27.7, 27.8 заалтуудыг баримтлан жилийн эцсийн ажлын үр дүнг тооцон амжилт гаргасан, байгууллага хамт олны зардал хэмнэсэн, ашиг орлого оруулсан хэлтэс алба, салбар нэгж, ажилтанг мөнгөн шагналаар урамшуулан шагнана. Шагналыг тус газрын захирлын зөвлөлөөр хэлэлцэж хамт олныг 500,000-аас доошгүй, ажилтанг 300,000-аас доошгүй мөнгөн урамшууллаар шагнаж урамшуулна.
- 3.12 Инженер, техникч, монтёр, түгээмэл мэргэжлийн ажилтнуудыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 27.7, 27.8 заалтуудыг баримтлан нийт ажилтан албан хаагчдаас доор дурдсан ажилтан албан хаагчдыг тус газрын захирлын зөвлөлөөр хэлэлцэж шийдвэрлэн ажлын үр дүнгээс шалтгаалан өргөмжлөл, мөнгөн шагнал, урамшуулал олгоно.

- 3.12.1 шилдэг ээлж
- 3.12.2 шилдэг инженер
- 3.12.3 шилдэг техникч, монтёр
- 3.12.4 шилдэг ажилтан

Дөрөв. Ажил, амралт, чөлөө олголт

- 4.1 Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож, биеэр эдлэх боломжоор хангана. Хэрэв ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд ээлжийн амралтын цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгоно.
- 4.2 Ажилтан доорх тохиолдлуудад цалинтай чөлөөг эдэлнэ.

- 4.2.1 Ажилтан хурим хийсэн бол ажлын 5 хоног
- 4.2.2 Үр хүүхэд нь хурим хийсэн бол ажлын 3 хоног
- 4.2.3 Төрсөн эцэг, эх, ах, эгч, дүү, гэр бүлийн хүн, үр хүүхэд, хадам эцэг эх нас барсан болон асрах бол ажлын 7 хоног, хот хоорондын унаагаар алслагдмал зайд явах бол ажлын 10 хоног
- 4.2.4 Эхнэр нөхрийн төрсөн ах, эгч, дүү нас барсан бол ажлын 5 хоног, хот хоорондын унаагаар алслагдмал зайд явах бол ажлын 7 хоног

- 4.3 Дээрх хугацаанд заасан хоногоос хэтрэхээр бол ажилтны өргөдөл хүсэлтийг харгалзан үзэж цалингүй чөлөө олгож болно.
- 4.4 Эцэгт шинээр төрсөн хүүхдээ асрахад нь зориулан ажлын 10 доошгүй өдрийн чөлөөг ажил олгогч олгож, тухайн хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний олговор олгоно.
- 4.5 Нярай хүүхэд үрчлэн авсан эцэг, эхийн аль нэг нь хүсэлт гаргасан бол ажил олгогч түүнд хүүхдийг нь 60 хоногтой болтол хугацаагаар дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжтэй чөлөө олгоно.

Мининг

Тав. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн стандартыг хангах талаар

5.1 ХАБЭА-ын шаардлага хангах, ХАБЭА-ыг сайжруулах төлөвлөгөөг нийтэд танилцуулах ба ХАБЭА-ын арга хэмжээний зардлыг батлагдсан төсвийн дагуу зарцуулна.

5.2 Ажилтны хөдөлмөрийн нөхцөл ажил үүргийн онцлог, улиралд нь тохируулан аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, өнгө үзэмжтэй, хийц загвар сайтай, чанартай материалаар стандартын дагуу хийсэн ажлын тусгай хувцас болон дүрэмт хувцас, хамгаалах хэрэгслээр хангаж ажиллана.

5.3 Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг компанийн болон харьяа байгууллагын хөрөнгөөр цэвэрлүүлж, ариутгуулж, засварлуулах.

5.4 Ажлын байрны нөхцөлийг сайжруулан гэрэлтүүлэг, салхивч, аюулгүй ажиллагааны бүрэн бүтэн байдал зэргийг хангаж ажлын байрны температурыг +18 С –ээс доошгүй хэмжээнд байлгах арга хэмжээнүүдийг авна. Улирлын онцлогоос хамааран шаардлагатай ажлын байранд нэмэлт эйркондэйшн бөгөөд агаар цэвэршүүлэгчийг байрлуулах /ХАБ ЭА-н тухай хуулийн 28.1.10, 28.1.14, 34, 35-р зүйл болон бусад зүйл заалтууд/

5.5 Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт ажилтнуудыг жилд нэг удаа хамруулах ба ажлын онцлог бүхий ажилтанг жилд 2-оос доошгүй удаа үзлэгт оруулж үзлэгийн зардлыг ажил олгогч хариуцан гаргана.

5.6 Нийт ажилтан албан хаагчдын гэнэтийн ослын болон эрүүл мэндийн даатгалыг үргэлжлүүлэн хийх ба даатгалын шимтгэлийг ажилтан, ажил олгогч хувь тэнцүүлэн хариуцна. Ажил олгогч 60%, ажилтан 40% -ийг гаргана.

5.7 ХАБЭА-г хариуцсан ажилтнаар, ХАБЭА-н мэргэжлийн ажилтанг ажиллуулах ба өөр мэргэжлийн ажилтанг томилсон тохиолдолд ХАБЭА-н тухай хуулийн 27.2, 27.4 дэх заалт болон 28-р зүйлийн заалтуудыг хэрэгжүүлж ХАБЭА-н сургалтад хамруулан сургалтын зардлыг ажил олгогч хариуцна.

5.8 Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын байгууллага нь доорх орон тооны бус зөвлөл, комиссын бүрэлдэхүүнийг байгуулан ажиллуулна.
Үүнд:

5.8.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан орон тооны бус зөвлөл /ажилтны/ ажиллах журам

5.8.2 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комисс, ажиллах журам /ХАБЭА-29.2, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм, ЗГ 2015.269 дүгээр тогтоол 1.6/

5.8.3 Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс, ажиллах журам

Зургаа. Ажилтны мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх талаар.

6.1 Ажилтны мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг чанарын өндөр түвшинд зохион байгуулж, түүнд зарцуулах зардлыг ажил олгогч жилийн төсөвтөө тусгаж батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу зарцуулна. Сургалтын чанарын талаар суралцагчид өөрсдөө заавал тайлагнана.

6.2 Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын мэргэшсэн боловсон хүчинг бэлтгэх, чадваржуулах, мэргэжлийн ажилтныг тухайн салбартаа ажиллах

боломжоор хангах, салбарт мэргэжилтэй албан хаагчдыг ажиллуулах бодлогыг дэмжиж хамтарч ажиллах.

6.3 Ажилтанд үндсэн ажлаасаа 3 хүртэлх сарын хугацаатай чөлөөлөгдөн байгууллагын захиалгаар суралцах хугацаанд түүнд цалинтай чөлөө олгоно.

6.4 Ажилтан өөрийн хүсэлтээр ажиллаж байгаа чиг үүргийнхээ дагуу 3 сар хүртэлх хугацаагаар сурах тохиолдолд ажилтны хүсэлтийг харгалзан цалинтай чөлөө олгож болно. 3 сараас дээш хугацаагаар суралцах тохиолдолд чөлөө олгох эсэх асуудлыг ажилтантай харилцан тохиролцож болно. Ажлын цагийн зохицуулалтыг хийж, ажлын байрыг хэвээр хадгална.

6.5 Ажилтан нь тухайн ажиллаж байгаа ажлынхаа дагуу мэргэжил, мэдлэг боловсролоо дээшлүүлэх зорилгоор суралцах бол байгууллага тухайн хүний ажлын санаачлага, чадварыг харгалзан нэмэлт сургалтын гэрээ байгуулан ажлын богиносгосон цагаар ажиллуулж болно.

6.6 Олон улсын болон дотоодын хурал зөвлөгөөн сургалтад явуулахдаа техник тоног төхөөрөмж дээр ажиллаж байгаа ИТА-д болон хэлтэс алба нэгжүүдээс тус бүр 1-ээс доошгүй хүнийг хамт олны санал, холбогдох болзлыг хангасан ажилтанг явуулна.

6.7 Техник технологийн шинэчлэлийн улмаас ирээдүйд ажлын байргүй болох магадлалтай ажилтанд мэргэжил дээшлүүлэх чиглэлээр ажлын байрны сургалт, давтан сургалтыг зохион байгуулж, өөр ажлын байранд шилжүүлэн ажиллуулах боломжоор хангана.

6.8 Тухайн байгууллага нь ур чадварын шалгалтыг 2 жилд 1 удаа явуулах бөгөөд сургалтын хөтөлбөрийг урьдчилан мэдэгдэж, хөтөлбөрийн дагуу сургалтыг явуулсаны дараа шалгалтыг зохион байгуулж явуулна. 50-аас дээш насны эмэгтэй, 55-аас дээш насны эрэгтэй ажилтан нь өөрөө хүсвэл шалгалтад орохгүй байх эрхтэй.

Долоо. Нийгмийн ахуй хангамжийн талаар

7.1 Нэг өдрийн хоол, унааны зардал Улаанбаатар хотод 4500, орон нутагт 4000 төгрөгийг олгоно.

7.2 Ажилтан болон түүний ар гэрт гачигдал тохиолдсон, хөгжлийн бэрхшээлтэй болон олон хүүхэдтэй эцэг эхэд доорх буцалтгүй тэтгэмжийг тухай бүрт олгоно. Үүнд:

7.2.1 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан нь эмнэлгийн байгууллагын шинжилгээ, магадлаагаар тогтоогдсон ажилтны ар гэрт ажилтны нэг сарын дундаж цалин хөлсийг 36 дахин нэмэгдүүлсэн нөхөн төлбөрийг нэг удаа олгоно.

7.2.2 Ажилтан өвчний болон гэнэтийн ослын улмаас амь насаа алдсан бол тухайн ажилтны ажилласан жил эрхэлж байсан ажлыг үл хамааран 1.500.000 /нэг сая таван зуун/ төгрөгийн тэтгэмжийг нэг удаа олгоно.

7.2.3 Ажилтны төрсөн эцэг, эх, ах, эгч, дүү, гэр бүлийн хүн, үр хүүхэд, хадам эцэг эх нас барсан бол 700.000 /долоон зуун мянган/ төгрөгийн тусламжийг олгож, шаардлагатай бол бусад төрлийн туслалцааг үзүүлнэ.

7.2.4 Ажилтны ар гэр байгалийн болон гэнэтийн аюул, осол учирсан бол 6 сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний туслалцааг нэг удаа үзүүлнэ. /жич 7.2.3 7.2.4 заалтууд нь тухайн байгууллагад 1 гэр бүлийн эхнэр нөхөр, төрсөн ах дүү нар нь ажиллаж байгаа тохиолдолд тэтгэмжийг аль нэгэнд нь олгоно/.

7.2.5 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилтанд хүүхдийн эмчилгээний зардалд зориулж гаргасан хүсэлт болон эмнэлгийн магадлагааг үндэслэн жилд 1

Миним

удаа 350.000 төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлнэ. шаардлагатай тохиолдолд цалинтай чөлөө олгож болно.

7.2.6 4 ба түүнээс дээш хүүхэдтэй ажилтан, өрх толгойлсон ганц бие эх, эцэгт хичээлийн шинэ жилийн нээлтийг тохиолдуулан жилд 1 удаа хүүхдийн хичээлийн хэрэгсэл авахад нь зориулж 2-16 насны хүүхэд тус бүрт 25.000 төгрөгийн тэтгэмж үзүүлнэ.

7.3 Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, жил бүрийн 6 дугаар сарын 1-ний өдрийг тохиолдуулан ажилтны 16 нас хүрээгүй хүүхэд бүрт гарын бэлэг гардуулна.

7.4 Тус байгууллагын ажилтан, харьяа өндөр настан /тухайн байгууллагын тушаалаар тэтгэвэрт гарсан/ зайлшгүй шаардлагаар байгууллагаас тусламж хүсч өөрөө хүсэлтээ гаргавал захирлын зөвлөлөөр хэлэлцэж бодит шалтгаантай гэж үзвэл ажилтанд 350.000 төгрөг, харьяа өндөр настанд 200.000, харьяа өндөр настан нас барсан бол 300.000 төгрөгийн мөнгөн тусламжийг жилд нэг удаа үзүүлнэ.

7.5 Ажилчдын эрүүл мэндийг дэмжих зорилгоор зохион байгуулдаг дотоодын тойрон аялалд, тухайн жилд хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан, олон жил үр бүтээлтэй ажилласан ажилчдаас тухайн гэрээний хугацаанд 20 хүртэл хүнийг ажил олгогчийн зардлаар аялуулна. /Улаанбаатар хотын албад болон орон нутгийн РТСГ-ын ажилчдын хүний тоог харгалзан хувь тэнцүүлэн оролцуулна/

7.6 Харилцаа холбооны байгууллагад ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх үүднээс орон сууцны газрыг олгох, байгууллагын тухайн эзэмшил өөрийн нөөц бололцоотой газарт орон сууц барих эрхийг олгох, дэмжлэг үзүүлэх.

7.7 Ажилчдын ахуй нөхцөлийг сайжруулахад анхаарч жил бүр тодорхой тооны ажилчдыг шинээр орон сууц худалдан авах, орон сууцны нөхцөлөө сайжруулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор 60 сая төгрөгийг байгууллагын төсөвт төсөвлөнө. /Үүнээс хотод 35,0 сая, хөдөө орон нутагт 25,0 сая/.

7.8 Гэр хашаа, орон сууц худалдан авахад хөнгөлөлт үзүүлэх, нөхцөл сайжруулахад нь санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг ил тод хэлэлцэж захирлын зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ. Ажилтан, албан хаагчдад орон сууцны дэмжлэг үзүүлэх журмын 6 дугаар зүйлд заасан дараалал тогтоох үзүүлэлтээр дүгнэнэ. Асуудлыг хэлэлцэхдээ Холбооны салбарт болон тус байгууллагад ажилласан жил, тэтгэвэрт гарах хугацааг харгалзан үзэж, АҮЭХ-ны төлөөллийг оролцуулж саналыг тусгаж байна.

7.9 Төрийн одон медалиар шагнагдсан ажилтанг байгууллагаас 300.000 төгрөг хүртэлх бэлэг дурсгалын зүйлээр урамшуулна.

7.10. "Хүндэт холбоочин"-д жилд нэг удаа 50.000 төгрөгийн тэтгэмж олгоно. /Ахмадууд мөн хамрагдана/.

7.11. Тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээнд зориулан тодорхой хэмжээний санхүүжилтийг жил бүр төсөвлөж, төсвийн дагуу зарцуулна.

7.12. Байгууллагын аварга шалгаруулах 5 төрөлт тэмцээнийг хэлтэс, алба, нэгжүүдийн дунд 4 дүгээр сард зохион байгуулж болно. Тэмцээнд гарах зардлыг ажил олгогч болон АҮЭХорооноос гаргана.

7.13. Байгууллагын үндсэн ажилтанд өвлийн бэлтгэл ажилд зориулан жилд гэр хороололд бол 2тн түлээ, сайжруулсан түлшний хөнгөлөлт үзүүлнэ.

7.14. Ажилтан дотоодын сувиллын газар эмчлүүлсэн тохиолдолд тухайн сувиллын зардлын 40%-ийг АО-оос, 10%-ийг АҮЭХ-оос олгоно

Найм. Үйлдвэрчний эвлэлийн хорооны үйл ажиллагааг явуулах нөхцөл бололцоог хангах талаарх ажил олгогчийн хүлээх үүрэг

8.1 Ажил олгогч нь АҮЭХ-г ажиллах нөхцөл бололцоогоор бүрэн хангаж байна. Үүнд: ҮЭХ-г ажлын байраар хангах, хурал зөвлөгөөн зохион байгуулах заал, танхим,

М.М.М.М.

шаардлагатай эдийн засгийн судалгаа, холбогдох тушаал шийдвэр, журмыг гаргаж өгнө.

8.2 Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн дагуу АҮЭХорооны дарга, тэргүүлэгчид, сонгуульт ажилтнууд 1 сар хүртэлх хугацаагаар сургалтад хамрагдах, олон улсын болон салбар, орон нутгийн хурал зөвлөгөөн, семинар, ярилцлагад оролцоход, цалинтай чөлөө олгож, санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

8.3 Ажил олгогч нь АҮЭХороог хамтын гэрээний төсөл боловсруулах, хэлэлцээ хийх болон үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх үүргийг хүлээнэ.

8.4 Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон ажилтнуудын эрх ашигтай холбогдох нийгмийн асуудлаар аливаа шийдвэр гаргахдаа АҮЭХороо болон салбарын ҮЭ-үүдийн холбоонд ажлын 15 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэж санал авсны үндсэн дээр шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах эрх бүхий хурал, зөвлөгөөнд ҮЭ-ийн хүсэлтийг нь харгалзан оролцуулна.

8.5 Ажилтны ҮЭХорооны даргыг өөрийн болон сонгосон хамт олных нь зөвшөөрөлгүйгээр өөр ажилд шилжүүлэх, захиргааны санаачлагаар ажлаас халах, түүнд сонгуульт үүрэгтэй нь холбогдуулан сахилгын шийтгэл оногдуулахгүй байх.

8.6 Ажилтны үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга нь тус байгууллагын захирлын зөвлөлийн хуралд биечлэн оролцох санал, хүсэлтээ илэрхийлэх эрхтэй.

8.7 РТҮС УТҮГазрын нягтлан бодогч болон Баян-Өлгий, Говь-Алтай, Хөвсгөл, Дорнод, Өмнөговь аймгийн Радио телевизийн сүлжээний газруудын ахлах нягтлан бодогч нар хөдөлмөрийн хөлс буюу түүнтэй адилтгах орлогын нэг хувиар бодож Үйлдвэрчний эвлэлийн гишүүний татварыг бэлэн бусаар хурааж, тухайн сард багтааж Голомт банканд дахь АҮЭХорооны 2201078291 тоот дансанд шилжүүлэх ба уг үйл ажиллагаанд ажил олгогчийн зүгээс ямар нэгэн саад учруулахыг хориглоно.

8.8 Орон нутгийн тэргүүлэгчид, 2 жилд нэг удаа Улаанбаатар хотод цугларч, ҮЭХ-ны тайлан, Хамтын гэрээ, төлөвлөгөө боловсруулах бөгөөд тухайн хүний зардлыг ажил олгогч хариуцна.

8.9 Байгууллагын төсөв хэлэлцэхээс өмнө хамтын гэрээнд оруулах саналыг жил бүрийн 3-р улиралд багтаан Захиргааны Удирдлагын Хэлтэс болон Санхүүгийн Хэлтэст танилцуулан төсөвт суулгах.

Ес. Үйлдвэрчний эвлэлийн хорооны хүлээх үүрэг

9.1 Ажилтнуудын хөдөлмөрлөх эрх, хууль ёсны ашиг сонирхолтой холбогдох асуудлаар хуулийн хүрээнд хамтын үйл ажиллагааг зохион байгуулж, олон жил ажилласан, орон тооны цомхтголд хамрагдсан гишүүдийг ҮЭХ-оос байр сууриа илэрхийлж эрх ашгийг нь хамгаална.

9.2 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулахад анхаарч байгууллагатай хамтарч ажиллана.

9.3 ҮЭ-ийн гишүүдийн хууль эрх зүй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон ур чадвар, мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх сургалтад ажилтнуудыг хамруулна.

9.4 Хот, орон нутгийн ҮЭ-ийн нэгжүүдтэй тогтмол харилцаж мэдээ, мэдээлэл солилцох, уулзалт зөвлөгөөн зохион байгуулж хамтран ажиллана.

9.5 Хамтын гэрээний төслийг боловсруулахад гишүүдийн санал, хүсэлтийг авч тусгах, гэрээний ач холбогдлыг сурталчлах, хамтарсан сургалт явуулж ажиллана.

9.6 ҮЭХорооноос зохиож байгаа ажилд идэвхтэй оролцдог, хорооны ажлыг дэмждэг гишүүдээс жилд бүлэг тус бүрээс 1 хүнийг 50,000 төгрөгөөр, ҮЭХ-ны оны тэргүүний бүлгийг 100,000 төгрөгөөр тэргүүлэгчдийн хурлын шийдвэрээр шагнаж урамшуулна.

9.7 Ажилчдын эрүүл мэнд, чөлөөт цаг, аялал жуулчлал, идэвхтэй амралт, олон нийтийн арга хэмжээ, соёл, урлаг спортын тэмцээн уралдаанд зориулж зарцуулах мөнгөн дүнг холбогдох журмын дагуу зарцуулна.

Уршил

9.8 Ар гэрт нь хүндэтгэн үзэх шалтгаантай ажилтны өргөдөл хүсэлтийг харгалзан тэргүүлэгч гишүүдийн саналыг үндэслэн жилд 1 удаа, 5-аас илүүгүй хүнд 100,000 төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлнэ. Энэ нь байгууллагаас тусламж олгосон ажилтанд олгох эсэхийг тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлэнэ.

9.9 Жилд бүлэг бүрээс 1 ажилтанг хувийн зардлаараа мэргэжлийн болон гадаад хэл, компьютерын сургалтад суралцах бол сургалтын гэрээ, үндсэн төлбөрийн баримт, сургалтын гэрчилгээ зэргийг үндэслэн 100,000 төгрөг хүртэлх тэтгэмжийг АҮЭХорооноос үзүүлнэ. Тэтгэмж авсан ажилтан 3 жилийн дараа дахин эрх үүснэ. Үйлдвэрчний эвлэлийн гишүүнээр элссэнээс хойш 1 жил ажиллаагүй ажилтанд хамаарахгүй.

9.10 ҮЭ-ийн гишүүдийн эрүүл мэндэд анхаарч, эмнэлэгт хэвтэж эмчлүүлж буй нөхцөлд 30,000 төгрөгийн тусламж жилд 1 удаа үзүүлнэ.

9.11 АҮЭХорооны үйл ажиллагаа явуулахад болон хурал, семинар, сургалт явуулахад зориулан санхүүжүүлнэ.

9.12 Улирал бүр үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг гаргаж, хяналтын хороогоор шалгуулж, дүгнэлт гаргуулна.

9.13 Нийт гишүүдэд хагас жил тутамд ажлын тайланг танилцуулна.

9.14 АҮЭХороо нь эв нэгдлийн сан байгуулж нийт хураасан татварын 5 хувийг байршуулна.

Арав. Хамтын гэрээний хэрэгжилт, хяналт, хүлээх үүрэг хариуцлага

10.1 Талууд хамтын гэрээний үүргийн хэрэгжилттэй холбоотой бүх мэдээллийг тогтмол солилцох үүрэг хүлээнэ.

10.2 Талууд хамтран хамтын гэрээний хэрэгжилт биелэлтийн явц байдлыг хагас жил тутамд дүгнэн хэлэлцэж хамт олонд мэдээлж байна.

10.3 Талууд хяналтыг улирал тутамд хийж тайланг танилцуулна.

10.4 Хамтын гэрээний үүрэг заалтыг биелээгүй тохиолдолд буруутай тал холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

10.5 Хамтын гэрээ байгуулах, биелүүлэх, хэрэгжүүлэх, тайлбарлах, нэмэлт өөрчлөлт оруулах, дүгнэх үед талуудын хооронд маргаан үүсвэл зөвшилцлийн журмаар урьдчилан шийдвэрлэх, харилцан тохиролцох арга хэмжээг авна. Хэрэв талууд харилцан тохиролцож чадахгүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.






10.6 Энэхүү гэрээний хавсралт болгон доорх бичиг баримтыг ажил олгогч нь ҮЭХороотой харилцан зөвшилцсөний үндсэн дээр батлан мөрдүүлнэ.

- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангах ХАБЭА-г сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө
- Ажилтанд олгох ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн жагсаалт эдэлгээний хугацаа, норм норматив






Миний

ГЭРЭЭ БАИГ УУЛСАН:

АЖИЛ ОЛГОГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

1. 
Захиргааны удирдлагын хэлтсийн дарга
2. 
Санхүүгийн хэлтсийн дарга
3. 
ХШҮХ-ийн дарга
4. 
ТХ-ийн дарга
5. 
МТХ-ийн дарга

АҮЭХОРООГ ТӨЛӨӨЛЖ:

1. 
МТХГТАХЭХ-ны дарга
2. 
РТҮС УТҮГ-ын АҮЭХ-ны дарга
3. 
ХШРА-ны тэргүүлэгч
4. 
ТТС-ийн тэргүүлэгч
5. 
ХЗТ ШУХ-ийн тэргүүлэгч

25
2022.05.30

Н. Хуудгын

